



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДЭРГЭДЭХ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас/факс: 261406

E-mail: info@frs.mn, http://www.frs.mn

2023.03.30 № 03

танай _____-ны № _____-т


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

“Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 7.1. дэх хэсэгт “Хяналтын зөвлөл үйл ажиллагааныхаа тайланг жил бүрийн эхний улиралд УИХ-д танилцуулна” гэж заасны дагуу тус зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

ДАРГА

Р.РИНЧИНБАЗАР



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДЭРГЭДЭХ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 03 дугаар сарын 30

Хяналтын зөвлөл нь “Санхүүгийн Зохицуулах Хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2006 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2 дахь хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Хорооноос гаргасан аливаа шийдвэртэй холбогдсон гомдлыг урьдчилан хянах, Хорооны үйл ажиллагаанд хяналт тавих, Хорооны үйл ажиллагааны талаар хөндлөнгийн аудитын гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй орон тооны бус байгууллага юм.

Хууль, журамд зааснаар Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд нэгээс доошгүй удаа хуралдах, хуралдааны товыг Хяналтын зөвлөлийн дарга тогтоохоор журамлагдсан байдаг.

УИХ-ын 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Хяналтын зөвлөлийн даргаар Р.Ринчинбазар, гишүүдээр Ж.Эрдэнэбилэг, А.Өнөржаргал, Б.Амарсанаа, Д.Цэрэнбадам нарыг томилсон.

Гишүүн Ж.Эрдэнэбилэг, Д.Цэрэнбадам нар 2021 онд, гишүүн Б.Амарсанаа 2022 онд Зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ тус тус УИХ-д хүргүүлж, гишүүн А.Өнөржаргал өвчний улмаас нас барсан. Зөвлөл бүрэлдэхүүний хувьд хуралдах, асуудал шийдвэрлэх боломжгүй болсон хэдий ч урьдчилан хянах эрх, үүрэг бүхий субъектийн хувьд Хорооны үйл ажиллагаа, бодлого, шийдвэртэй холбоотой иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч дурдсан асуудал, хариуцагчийн тайлбар, бусад холбогдох баримт материалыг хянаж гомдол гаргагч цаашид эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх чиглэлээр санал, зөвлөмж, албан бичиг хүргүүлж ажиллалаа.

Тус зөвлөл 2022 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Хяналтын зөвлөлд иргэд байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

1. “Ди Пи Юу Эс” ХХК-ийн захирал Х.Шинэцэцэгээс 2022.01.25-ны өдөр ирүүлсэн Хорооны 2022 оны 14 дүгээр тогтоол буюу Үнэт метал болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай тогтоолыг хүчингүй болгох тухай гомдлыг хянан үзэхэд Хороо хуулиар олгосон эрх үүргийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн асуудлыг шийдвэрлэсэн байх тул тогтоолыг хүчингүй болгох үндэслэлгүй болохыг гомдол гаргагчид албан бичгээр мэдэгдсэн.

2. Иргэн Н.Баярсайханаас 2022.04.18-ны өдөр ирүүлсэн Даатгалын нөхөн төлбөрийн асуудлаар гаргасан гомдлыг хянан үзэхэд уг асуудлаар иргэн Баярсайхан нь Хороонд гомдол гаргаж шийдвэрлүүлсэн байх бөгөөд хариуцагчийн тайлбар үндэслэлтэй байх тул гомдлын

шаардлагыг хангаж шийдвэрлэх боломжгүй талаар үндэслэл, тайлбар бүхий хариуг албан бичгээр хүргүүлсэн.

3. Иргэн Б.Тулгаас 2022.06.27-ны өдөр ирүүлсэн Хорооны 2022 оны 173 дугаар тогтоолыг хүчингүй болгох /"Хөтлийн цемент шохой" ХК-ийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасах тухай/ шийдвэрийг гаргахдаа Хороо Захиргааны ерөнхий хуульд заасан урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлээгүй тухай гомдол;

4. "Гриндинг процесс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Батбилэгээс 2022.07.01-ний өдөр ирүүлсэн Хорооны 2022 оны 173 дугаар тогтоол нь хуульд нийцээгүй, илт хууль бус захиргааны шийдвэр байх тул тогтоолын нэхэмжлэгчид холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай гомдол;

5. "MDM партнерс" ХХН-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал В.Мандахаас 2022.08.10-ны өдөр ирүүлсэн "Хорооны Улсын байцаагчийн 2022 оны 02 дугаартай албан шаардлага нь үнэт цаас нэгтгэх хүсэлт гаргасан үнэт цаас гаргачийн үнэт цаасны арилжааг Улсын байцаагчийн албан шаардлагаар зогсоосноор үнэт цаасны ханш унаж хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашиг хохирох нөхцлийг бүрдүүлж байгаа бөгөөд Хороо хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, Хорооны улсын байцаагч, бусад эрх бүхий албан хаагчдаас тухайн үнэт цаасны хяналтын багцыг эзэмшигчтэй үгсэн хуйвалдсан, үнэ ханшийг зохиомлоор тогтооход албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан байж болзошгүй талаар гаргасан гомдол;

6. "Өмгөөллийн грата интернэшн монголиа" ХХН-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч В.Болормаагаас 2022.08.29-ний өдөр ирүүлсэн Хорооны үйл ажиллагаанд холбогдох буюу Хорооны албан ёсны цахим хуудсанд тавигдсан мэдээлэл нь нэр бүхий иргэний тухайлбал тус ХХН-ийн үйлчлүүлэгчийн нэр хүндэд халдсан тухай гомдол;

7. "Монгол хувьцаа" ҮЦК-ийн захирал Г.Буянжаргалаас 2022.10.13-ны өдөр ирүүлсэн Хорооны 2022 оны 331 дүгээр тогтоолоор тус компанийн үнэт цаасны зах зээлд брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн нь хууль бус, Хорооны үйл ажиллагаанд холбогдох буюу Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны эрсдэл, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахдаа шалгалтын тайландаа тайлбар, зөвлөмжөө тусгахгүй зөвлөн туслах чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байгаа нь компани зөрчлөө зөв, хурдан засах боломж олгохгүй байх, үйл ажиллагааг нь зогсоох, дампууруулах зорилго агуулж байгаа тухай гомдол;

8. "Азиа пассифик секьюритис" ҮЦК-ийн гүйцэтгэх захирал Б.Батчимэгээс 2022.10.18-ны өдөр ирүүлсэн Хорооны 2022 оны 495 дугаар тогтоолоор "Азиа пассифик секьюритис" ҮЦК-ийн үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх усгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор зөвхөн нэг компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөөд зогсохгүй үнэт цаасны зах зээлд хамтран ажиллагч харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашигт сөргөөр нөхөөлж байгаа тухай гомдолтой тус тус танилцан "Санхүүгийн Зохицуулах Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн ажиллах журам"-ын 4.9-д зааснаар Зөвлөл гомдлыг хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэх зохицуулалттай боловч 3 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөхөөр Улсын Их Хуралд хүсэлтээ гаргасан, дараагийн гишүүд томилогдоогүй тул Зөвлөл бүрэлдэхүүний хувьд асуудлыг хянан шийдвэрлэх боломжгүй болохыг бичгээр мэдэгдсэн.

Түүнчлэн иргэд, байгууллагаас ирүүлсэн СЗХ-оос батлан гаргасан хэм хэмжээ тогтоосон акт, үйл ажиллагаатай холбогдох зарим асуудлаар тайлбар гаргуулж, зарим гомдлыг харьяалалын дагуу шилжүүлэн, эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийж зохицуулалттай этгээд, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдээс ирүүлсэн хүсэлт саналыг шуурхай шийдвэрлэж байх талаар Ажлын албанд зохих үүрэг, чиглэл өгч ажиллалаа.

СЗХ-ноос тайлбар, материал авах, өргөдөл гомдол шилжүүлэх, санал, дүгнэлт, тайлбар баримт хүргүүлэх, Хороо болон бусад байгууллага, иргэдэд өргөдөл, гомдол, албан тоотын хариу, шийдвэр хүргүүлэх, материал шилжүүлэх зэрэг агуулгуудаар нийт 17 албан бичиг явуулсан ба байгууллага иргэдээс ирүүлсэн 5 албан бичиг, 8 өргөдлийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж ажиллалаа.

Зарим иргэдээс ирүүлсэн хувьцаа эзэмшилтэй холбоотой гомдлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах үүднээс холбогдох зөвлөгөө, тайлбарыг өгч, шаардлагатай тохиолдолд харьяалах байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүллээ. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, компанийн хэлбэрийг өөрчилсөнтэй холбогдуулан өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх, эсхүл шинээр бий болсон компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх эрхээ хэрэгжүүлэх тухайд хувьцаа эзэмшигч бүрт мэдээлэл хүргэх, хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, улмаар тэдэнд оногдох мөнгөн хөрөнгө, ногдол ашгийг хуваарилан олгуулах талаар Эдийн засгийн байнгын хорооноос холбогдох талуудад үүрэг болгох нь зүйтэй гэж үзэж буйг дахин уламжилж байна.

-----oO-----